

	“МИК ХОЛДИНГ” ХК	Төлөв: Батлагдсан
Эрсдэлийн удирдлагын бодлого	Хувилбар 1.3	Баталсан огноо: 2021/03/19

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1.1. Зорилго

“МИК Холдинг” ХК болон түүний охин компанийн (цаашид “Компани” гэх)-ийн бизнесийн үйл ажиллагаанд учирч буй болон болзошгүй эрсдэлийг зохистой түвшинд удирдах эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэвшүүлэх, эрсдэлийн соёлыг төлөвшүүлэхэд оршино.

#### 1.2. Хамрах хүрээ

1.2.1. Энэхүү бодлого нь компанийн ТУЗ болон бүх газар нэгжийн үйл ажиллагаанд хамаарна.

#### 1.3. Нэр томъёоны тайлбар

- 1.3.1. Эрсдэл<sup>1</sup> (*Risk*) – Тодорхойгүй байдлаас компанийн бизнесийн төлөвлөгөө, стратегийн зорилтод нөлөөлөх нөлөө;
- 1.3.2. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо<sup>2</sup> (*Risk management framework*) – Компанийн зорилго, зорилтод сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлийг зохистой түвшинд удирдах бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны цогц;
- 1.3.3. Эрсдэлийн бүртгэл<sup>3</sup> (*Risk register*) – Компанийн хэмжээнд тулгарч буй болон болзошгүй эрсдэл тус бүрийг тодорхойлж, үнэлсэн үнэлгээ, авах арга хэмжээний эрэмбэ, үлдэгдэл эрсдэлийн үнэлгээний нэгдсэн мэдээллийн бүртгэл;
- 1.3.4. Эрсдэл хариуцагч<sup>4</sup> (*Risk owner*) - Эрсдэлийг удирдах эрх, үүрэг бүхий газар, нэгжийн удирдлага;
- 1.3.5. Эрсдэлийн соёл<sup>5</sup> (*Risk culture*) - Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд эрсдэлийн удирдлагын ач холбогдлыг бүрэн танин мэдэж, эрсдэлийн удирдлагад оролцох өөрийн үүрэг, хариуцлагаа ойлгосны үндсэн дээр төлөвшүүсэн хандлага болон ур чадвар;
- 1.3.6. Хүлээн зөвшөөрөх эрсдэл<sup>6</sup> (*Risk appetite*) – Компанийн тогтоон барихыг зорьж буй буюу бизнесийн төлөвлөгөө, стратегийн зорилтод хүрэхийн тулд хүлээн зөвшөөрч буй эрсдэлийн төрлүүд болон түвшинг;
- 1.3.7. Эрсдэлийн хяналт өөрийгөө үнэлэх (*Risk control self assessment – RCSA*) – Компанийн эрсдэл болон түүний хяналт зохицуулалтын үр дүнтэй байдлыг шалгаж баталгаажуулах үйл ажиллагаа;
- 1.3.8. Эрсдэлийн гол үзүүлэлт (*Key risk indicator - KRI*) - Эрсдэлийг удирдах явцад хянах шаардлагатай гол үзүүлэлт;
- 1.3.9. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үндсэн баримт бичиг – Компанийн эрсдэлийг зохистой түвшинд удирдан зохион байгуулахад шаардлагатай эрсдэлийн бодлого, дүрэм, журам, аргачлал.

2. <sup>1,2,3,4,6</sup> ISO 31000:2018 стандартын ISO/Guide 73:2009 -ийн тодорхойлолт

3. <sup>5</sup> АНУ-ын Poole College of Management-ийн Enterprise risk management (ERM) Initiative-ийн тодорхойлолт

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
Эрсдэлийн удирдлагын бодлого	Хувилбар 1.3		Баталсан огноо: 2021/03/19

## ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ЗАРЧИМ

- 2.1. Компани бизнесийн үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд, эрсдэлийг зохистой түвшинд удирдан, ёс зүйтэй, шударга байдлаар явуулах;
- 2.2. Компани хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, бизнесийн зорилгодоо хүрэх;
- 2.3. Компанийн ажилтан бүр өөрийн хариуцсан үйл ажиллагааны эрсдэлийн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэгч байх;
- 2.4. Компанийн бүх түвшний удирдах ажилтнууд хариуцсан үйл ажиллагааны эрсдэл хариуцагч байж, компанийн эрсдэлийн соёлыг хэвшүүлэхд бүх талаар үлгэр жишээ болж ажиллах;
- 2.5. Бүх ажилтны хамтын оролцоотойгоор эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, мэдээллийг тогтмол сайжруулах замаар компанийн эрсдэлийн соёлыг хэвшүүлж ажиллах;
- 2.6. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үндсэн баримт бичгийн хүрээнд газар, нэгжүүд өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу эрсдэлийг үр дүнтэй, зохистой түвшинд удирдах зохицуулалтыг холбогдох журам, зааварт тусган, хэрэгжүүлэх;
- 2.7. Компанийн бизнес төлөвлөгөө нь хүлээн зөвшөөрөх эрсдэлтэй уялдсан, зах зээлийн нөхцөл байдалд компанийд учирч болзошгүй бодит алдагдлыг бууруулах, удирдахад чиглэгдсэн байх;
- 2.8. Компанийн эрсдэлийн зэрэглэсэн матриц/heat map/-ийг гаргаж, бизнес төлөвлөгөөнд тусгадаг байх;
- 2.9. Хүлээн зөвшөөрөх эрсдэл нь тоон болон чанарын тодорхой шалгуур үзүүлэлт, үндсэн зарчмууд дээр үндэслэн, уялдаа холбоотой тодорхойлогддог байх.

## ГУРАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.1. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны бүтэц бүрэлдэхүүнд Төлөөлөн удирдах зөвлөл /“ТҮЗ” гэх/, түүний дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо /“ЭҮХ” гэх/, Гүйцэтгэх удирдлага болон түүний дэргэдэх хороод /”Гүйцэтгэх удирдлага” гэх/, Дотоод аудитын нэгж, Эрсдэлийн удирдлагын нэгж болон бусад газар, нэгжүүд хамаарна.

### 3.2. ТҮЗ-ийн эрх, үүрэг

- 3.2.1. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны зохистой засаглалын бүтцийг бий болгох;
- 3.2.2. Эрсдэлийн удирдлагын бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийг батлах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.2.3. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд дотоод аудитаас баталгаажуулалт авах замаар хяналтыг хэрэгжүүлэх;
- 3.2.4. Компанийн гол эрсдэлүүд, тэдгээрт авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд болон тэдгээрийн хяналтын тайлантай танилцах, хэлэлцэх;

### 3.3. ЭҮХ-ны эрх, үүрэг

- 3.3.1. Эрсдэлийн удирдлагын бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэл, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнтэй байдлыг хянаж дүгнэх;
- 3.3.2. Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны үндсэн баримт бичгүүдийг хэлэлцэж дүгнэх, чиглэл өгөх;
- 3.3.3. Эрсдэлийн соёлыг бэхжүүлэх, тасралтгүй сайжруулалтыг дэмжин ажиллах;
- 3.3.4. Компанийн гол эрсдэлүүд, тэдгээрт авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд болон тэдгээрийн хяналтын тайлантай танилцах, хэлэлцэх;

 <b>“МИК ХОЛДИНГ” ХК</b>	Төлөв: Батлагдсан	
Эрсдэлийн удирдлагын бодлого	Хувилбар 1.3	Баталсан огноо: 2021/03/19

3.3.5. Батлагдсан эрсдэлийн удирдлагын бодлого, хүлээн зөвшөөрөгдхөх эрсдэл зэрэг эрсдэлийн удирдлагын тогтолцооны үндсэн баримт бичгүүдийн хүрээнд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны тайлантай хагас жил тутам танилцаж, удирдан чиглүүлэх;

#### **3.4. Гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг**

- 3.4.1. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой эрх, үүрэг хариуцлага болон шаардлагатай нөөцийг хуваарилах;
- 3.4.2. Компанийн бизнесийн төлөвлөгөө, стратегийн зорилтуудыг боловсруулахдаа тэдгээрээс үүсч болзошгүй эрсдэлүүдийг авч үзэж төлөвлөх;
- 3.4.3. ТУЗ-өөс баталсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хүрээнд шийдвэр гаргах;
- 3.4.4. Компанийн эрсдэл хариуцагчийн эрсдэлийн удирдлагын үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг хангуулах;
- 3.4.5. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны гүйцэтгэл, хяналтын тайлантай хагас жил тутамд танилцах;
- 3.4.6. Эрсдэлийн удирдлагын бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн гүйцэтгэл, хэрэгжилтийн тайланг жилд 1-ээс доошгүй удаа ТУЗ-д танилцуулах;
- 3.4.7. ТУЗ-өөс олгогдсон эрх хэмжээнээс хэтэрсэн эсхүл хүлээн зөвшөөрөх эрсдэлээс давсан тохиолдол үүссэн тухай бүр ТУЗ эсвэл түүний дэргэдэх хороонд танилцуулах.

#### **3.5. Дотоод аудитын нэгжийн үүрэг**

- 3.5.1. Эрсдэлд суурисан дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, компанийн үйл ажиллагааны процесс, компанийн засаглалын тогтолцооны үр ашигтай байдлыг хараат бус, бодитой үнэлэх, баталгаажуулах;
- 3.5.2. Аудитын үр дунд гүйцэтгэх захирал, түүний удирдлагын багт зөвлөх, ТУЗ-ийг бодит мэдээллээр хангах, тайлагнах.

#### **3.6. Эрсдэлийн удирдлагын нэгжийн үүрэг**

- 3.6.1. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үндсэн баримт бичгүүдийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, удирдах;
- 3.6.2. Компанийн нэгдсэн эрсдэлийн бүртгэлийг хөтлөх, түүний үнэн зөв байдалд хяналт тавих, нэгдсэн эрсдэлийн бүртгэлийн гол үзүүлэлтийн хяналт (KRI)-ыг хэрэгжүүлэх;
- 3.6.3. Эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу эрсдэл хариуцагч болон ажилтнуудад эрсдэлийг зохистой удирдах мэдлэг олгох, сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- 3.6.4. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны Эрсдэлийн хяналт өөрийгөө үнэлэх аргачлалыг боловсруулах, эрсдэлийн дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх;
- 3.6.5. Хүлээн зөвшөөрөх эрсдэлд хяналт тавьж, хэтэрсэн тохиолдолд холбогдох газар нэгжид эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг үүрэг болгох;
- 3.6.6. Компанийн нэгдсэн эрсдэлийн бүртгэл, хяналтын тайланг улирал бүр Гүйцэтгэх удирдлагад танилцуулах;
- 3.6.7. Компанийн өндөр үнэлгээтэй Топ-10 эрсдэлийн дэлгэрэнгүй, нэгдсэн эрсдэлийн бүртгэлийн бүтэц, түүний өөрчлөлт, хэрэгжилтийг хагас жил тутам Гүйцэтгэх удирдлагад, ЭУХ-нд тус тус Хавсралт №1-т заасан агуулгын хүрээнд танилцуулах;

	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
Эрсдэлийн удирдлагын бодлого	Хувилбар 1.3		Баталсан огноо: 2021/03/19

- 3.6.8. Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц томоохон өөрчлөлт гарах болон шаардлагатай тохиолдол гарах тухай бүрт тэдгээртэй холбоотой эрсдэлийг үнэлж, үнэлгээний үр дүн болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийг шинэчлэх эсэх саналыг Гүйцэтгэх удирдлага болон ЭУХ-нд танилцуулах;
- 3.6.9. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үйл явцуудын үр дүнтэй болон үр ашигтай байдлыг давтамжтай дахин хянах, тасралтгүй сайжруулах санал боловсруулах;
- 3.6.10. Чиг үүргийнхээ хүрээнд компанийн засаглал, комплаенс, дотоод аудит болон хууль эрхзүйн нэгжтэй ажил үүргийг давхцалгүйгээр харилцан дэмжин, хамтарч ажиллах;
- 3.6.11. Гүйцэтгэлийн удирдлага, төсөв, төлөвлөгөө, шийдвэр гаргалтад эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, аргачлалаар дэмжлэг үзүүлэх.

### 3.7. Газар нэгжийн үүрэг

- 3.7.1. Газар нэгж бүр үйл ажиллагааныхаа чиг үүргийн дагуу өдөр тутамд тулгарах эрсдэлийг удирдах, холбогдох хяналтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллах;
- 3.7.2. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тэдгээрийг тайлагнах;
- 3.7.3. Газар нэгжийн удирдлага нь эрсдэлийн удирдлагын үүрэг, хариуцлагыг ажилчид даа таниулж, тэднийг эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай сургалтад хамруулах;
- 3.7.4. Газар нэгжийн удирдлага нь холбогдох эрсдэлийн удирдлагын үүрэг, хариуцлагыг ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгах бөгөөд хүлээсэн үүрэг, хариуцлагын хэрэгжилтийг ажилтны гүйцэтгэлийн үнэлгээтэй нэгтгэх;
- 3.7.5. Үйл ажиллагааныхаа чиг үүргийн дагуу эрсдэлийн төрөл, түүнийг үнэлэх, удирдах арга аргачлалыг шинэчлэх, өөрчлөх, хүлээн зөвшөөрөх эрсдэлийг өөрчлөх, шинэчлэн тогтоох үндэслэл бүхий хүсэлт болон аливаа эрсдэлийн тохиолдол тэдгээрийн мэдээлэл, үнэлгээг тухай бүр Эрсдэлийн удирдлагын нэгжид хүргүүлэх;
- 3.7.6. Гуравдагч этгээдээр ажил гүйцэтгүүлэх явцад тохиолдож болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хяналт тавих.

## ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ

### 4.1. Эрсдэлийн төрөл

- 4.1.1. Компанийн үйл ажиллагаа, бизнесийн тасралтгүй байдлыг хангахад учирч болзошгүй эрсдэлийг дараах байдлаар ангилж, Хавсралт №2-т заасан бүтцийн дагуу зохистой түвшинд удирдаж ажиллана. Үүнд:
  - 4.1.1.1. *Стратегийн эрсдэл (Strategic risk)* –Бизнесийн орчинд аюул эсхүл тодорхойгүй байдал тулгарснаас шалтгаалан компани бизнес төлөвлөгөө, стратегийн зорилтод хүрч чадахгүй байх эрсдэл.
    - a) *Бизнесийн төвлөрлийн эрсдэл (Business concentration risk)* - Компанийн бизнесийн үйл ажиллагаа, стратеги зорилтууд, бизнесийн салбар, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэт төвлөрлөөс шалтгаалан сөрөг нөлөө үүсэх эрсдэл;
    - b) *Хууль эрхзүйн эрсдэл (Legal risk)*- Зохицуулалт, хууль эрхзүйн орчны өөрчлөлт, улс төрийн тогтвортгүй байдлаас шалтгаалан компанийн бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл;

	“МИК ХОЛДИНГ” ХХК	Төлөв: Батлагдсан
Эрсдэлийн удирдлагын бодлого	Хувилбар 1.3	Баталсан огноо: 2021/03/19

c) *Нэр хүндийн эрсдэл (Reputational & Social media risk)* – Компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй гадаад, дотоод нөхцөл байдал болон Нийгмийн цахим сүлжээний сөрөг хандлагаас үүсэх эрсдэл.

4.1.1.2. Зээлийн эрсдэл (*Credit risk*) – Компанийн зээлийн үүрэг гүйцэтгэгч эсвэл харилцагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй улмаас санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл.

a) *Зээл чанаргүй болох эрсдэл (Credit default risk)* – Компанийн худалдан авсан зээлийн үүрэг гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл;

b) *Харилцагч талын эрсдэл (Counterparty risk)* – Компанийн худалдан авсан багцад гэрээний дагуу үйлчилгээ үзүүлж буй этгээд, худалдагч тал болон мөнгөн хөрөнгө байршиулсан банк санхүүгийн байгууллага гэрээний үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл;

c) *Хөрөнгө оруулалтын эрсдэл (Investment risk)* – Компанийн хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй өгөөжтэй холбоотой алдагдал хүлээх эрсдэл.

d) *Барьцаа хөрөнгийн эрсдэл (Collateral risk)* - Компанийн худалдан авсан зээлийн барьцаа болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ буурч, санхүүгийн алдагдал хүлээх эрсдэл.

4.1.1.3. Зах зээлийн эрсдэл (*Market risk*) – Компанийн эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийн үнэлгээнд өөрчлөлт орж, компани алдагдал хүлээх эрсдэл;

a) *Хүүгийн эрсдэл (Interest rate risk)* – Зах зээл дэх хүүгийн өөрчлөлтөөс шалтгаалан компанийн ирээдүйн хүүгийн мөнгөн урсгалд нөлөөлөх эрсдэл;

b) *Валютын ханишийн эрсдэл (Foreign exchange risk)* – Компанийн хөрөнгө, эх үүсвэр гадаад валютаар илэрхийлэгдсэн эсхүл хөрөнгө өөр валютаар байрших үед гадаад валютын ханишийн өөрчлөлтөөс учирч болох эрсдэл;

c) *Системийн эрсдэл (Systemic risk)* – Үйл ажиллагаа явуулж буй салбарын өөрчлөлт, тогтвортгүй байдал компанийд сөргөөр нөлөөлөх эрсдэл;

4.1.1.4. Хөрвөх чадварын эрсдэл (*Liquidity risk*) - Компани гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадвар алдагдах эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд төлөвлөгдөөгүй зардал гаргах нөхцөл байдал үүсэх эрсдэл.

a) *Төлбөр гүйцэтгэх чадварын эрсдэл (Funding liquidity or cash flow risk)* – Компани өр төлбөрөө цаг тухайд нь гүйцэтгэж чадахгүй байх эрсдэл;

b) *Түргэн хөрвөх хөрөнгийн эрсдэл (Market liquidity risk, also referred to as asset/product risk)* - Компанийн түргэн хөрвөх чадвартай актив хүрэлцээгүй болох эрсдэл;

c) *Урьдчилан төлөлтийн эрсдэл (Prepayment risk)* – Компанийн худалдан авсан зээлийн багцын эргэн төлөлт нь хугацаанаас өмнө төлөгдсөнөөр компанийн ирээдүйн төлөвлөгдсөн орлого алдагдах эрсдэл.

4.1.1.5. *Үйл ажиллагааны эрсдэл (Operational risk)* – Компанийн бизнес зорилтод сөргөөр нөлөөлж болзошгүй үйл ажиллагааны тохиромжгүй, доголдолтой байдал, ажилтан, мэдээллийн хөрөнгө, систем болон гадаад хүчин зүйлсээс шалтгаалан үүсэх санхүүгийн болон санхүүгийн бус алдагдал хүлээж болзошгүй эрсдэл.

 <p><b>“МИК ХОЛДИНГ” ХК</b> УЧИРДЛАГЫН ПРОЦЕСС</p>	“МИК ХОЛДИНГ” ХК		Төлөв: Батлагдсан
	Эрсдэлийн удирдлагын бодлого	Хувилбар 1.3	Баталсан огноо: 2021/03/19

- a) *Процессоос хамаарсан эрсдэл* (Process risk) – Процессын тохиромжгүй, доголдолтой байдлаас болж Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эсхүл нөлөөлж болзошгүй эрсдэл;
  - b) *Ажилтнаас хамаарсан эрсдэл* (Human resource risk) – Ажилтны санаатай болон санамсаргүй алдаанаас болж Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эсхүл нөлөөлж болзошгүй эрсдэл;
  - c) *Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл* (Information security risk) – Мэдээлэл эсхүл мэдээллийн системийн доголдолтой байдлаас болж байгууллагын мэдээллийн нууцлал, хүртээмжтэй, үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлөх эсхүл нөлөөлж болзошгүй эрсдэл;
  - d) *Гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан эрсдэл* (External event risk) – Гадаад нөхцөл байдлаас шалтгаалан компанийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл учрах эрсдэл;
  - e) *Загварчлалын эрсдэл* (Model risk) - Компанийн санхүүгийн болон бусад тооцооллыг гаргахад ашигласан системийн загварчлалаас шалтгаалсан алдагдал хүлээх эрсдэл.
- 4.1.1.6. *Хүрээлэн буй орчны эрсдэл* (Environmental risk) – Компанийн үйл ажиллагаанаас үүдэн ус, агаар, хөрс зэрэг хүрээлэн буй байгаль орчинд эсхүл ажиллах хүчин, харилцагч зэрэг хүнд нөлөөлөх сөрөг нөлөөлөл.
- 4.1.1.7. *Комплаенсийн эрсдэл* (Compliance risk) – Комплаенсийн үүргийг хэрэгжүүлээгүйн улмаас бий болох компанийн нэр хүнд, санхүүгийн байдал эсвэл үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал.

## ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ПРОЦЕСС

### 5.1. Эрсдэлийн удирдлагын процесс

5.1.1. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хоорондоо харилцан хамааралтай, тасралтгүй үргэлжлэх дараах 3 эрсдэлийн үйл ажиллагаа (Процесс)-с бүрдэнэ.

- 5.1.1.1. *Эрсдэлийг үнэлэх process* (Risk assessment) – Эрсдэлийг илрүүлэн тодорхойлох (Risk identification), түүнд шинжилгээ хийж (Risk analysis), эрсдэлийг үнэлэх, дүгнэх (Risk evaluation) зэрэг үйл явц;
- 5.1.1.2. *Эрсдэлд арга хэмжээ авах process* (Risk treatment) – Үнэлэлт дүгнэлт хийгдсэн эрсдэлийг бууруулах арга хэмжээ эсхүл тухайн эрсдэлд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг тогтоох үйл явц;
- 5.1.1.3. *Эрсдэлийн мониторинг буюу хяналт тавих process* (Risk monitoring) - Компанийн нэгдсэн эрсдэлийн бүртгэлийг хянах болон эрсдэлийн гол шалгуур үзүүлэлтийн хяналт (KRI)-ыг хийх үйл явц.

- 5.2.2. Компанийн үйл ажиллагаанд тохиолдсон эсхүл тохиолдож болзошгүй эрсдэлийг илрүүлэн, тодорхойлсон эрсдэл бүрийг нэгдсэн эрсдэлийн бүртгэлд бүртгэж, хянана.
- 5.2.3. Эрсдэлийн бүртгэл нь эрсдэлийн анхны үнэлгээ болон үлдэгдэл эрсдэл, авах арга хэмжээний төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэл зэргийг тусгасан байна.
- 5.2.4. Эрсдэлийг удирдахад зайлсхийх, шилжүүлэх, бууруулах, хүлээн зөвшөөрөх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллана.

### 5.2. Эрсдэлийн үнэлгээний аргачлал

- 5.2.1. Эрсдэлийг тохиох магадлал болон хүчин зүйлсийн нөлөөллөөр үнэлнэ.
- 5.2.2. Эрсдэлийн хүчин зүйлсийн нөлөөллийг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжинэ.

	“МИК ХОЛДИНГ” ХК	Төлөв: Батлагдсан
Эрсдэлийн удирдлагын бодлого	Хувилбар 1.3	Баталсан огноо: 2021/03/19

5.2.3. Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах нарийвчилсан зохицуулалтын үйл ажиллагааг холбогдох журам, арга, аргачлалын дагуу хэрэгжүүлнэ.

### **ЗУРГАА. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ЭРСДЭЛ**

- 6.1. Компани боломжит эрсдэлийн төрөл тус бүрт хүлээн зөвшөөрөх эрсдэлийн зохистой түвшинг тогтоон, хянаж ажиллана.
- 6.2. Компани хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинг тогтоох боломжгүй эрсдэлийн төрөл тус бүрийн хувьд холбогдох журам, зааврын дагуу эрсдэлийн үнэлгээ хийж, “Хүлээн зөвшөөрөх түвшин”-д удирдахыг зорьж ажиллана.
- 6.3. Хүлээн зөвшөөрөх эрсдэлийг компанийн бизнесийн зорилт, хувьцаа эзэмшигчдийн хүлээлт, бонд эзэмшигчдийн хүлээлт, макро, микро түвшний нөлөөлөл (зах зээлийн нөхцөл байдал, эдийн засгийн нөхцөл байдал гэх мэт), компанийн санхүүгийн тренд, сценари, тоон болон чанарын судалгаанд үндэслэн тогтооно.
- 6.4. Хүлээн зөвшөөрөх эрсдэлийг жилд нэгээс доошгүй удаа эргэн хянана.

### **ДОЛОО. БУСАД**

- 7.1. Энэхүү бодлого нь Эрсдэлийн удирдлагын Олон Улсын стандартад нийцсэн байна.
- 7.2. Бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Эрсдэлийн удирдлагын нэгжээс боловсруулж холбогдох нэгжийн санал, зөвлөмжийн хамт Гүйцэтгэх удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, Эрсдэлийн удирдлагын хорооны дүгнэлтийн дагуу ТҮЗ-өөр батлуулна.
- 7.3. Эрсдэлийн удирдлагын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор газар, нэгжүүд холбогдох үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг тусгасан журмыг боловсруулан, мөрдөж ажиллана.
- 7.4. Энэхүү бодлогыг зөрчсөн тохиолдолд хөдөлмөрийн тухай хууль, түүний дагуу байгуулсан хөдөлмөрийн гэрээ, контракт, нууц үл задруулах гэрээ болон компанийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу арга хэмжээ авна.